




ГЭР БҮЛИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Хүний эрхийн түгээмэл тунхаглалын Арван зургадугаар зүйлийн 1-д “Насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хүмүүс арьс, яс үндэс, шашин шүтлэгтэй холбогдсон аливаа хязгаарлалтгүйгээр гэрлэх, өрх тусгаарлах эрхтэй. Тэд гэрлэхдээ, гэрлэснийхээ дараа болон гэрлэлтээ цуцлуулах үед тэгш эрх эдлэнэ” гэж, 2-т “Эрэгтэй, эмэгтэй хоёр хүн чөлөөтэй харилцан бүрэн зөвшөөрсөн нөхцөлд гэрлэж болно” гэж, 3-т “Гэр бүл бол нийгмийн жам ёсны үндсэн нэгж мөн бөгөөд нийгэм төрөөр хамгаалуулах эрхтэй” гэж тус тус заасныг үндэслэн аливаа улс орон бүр Гэр бүлийн хууль болон түүнтэй адилтгах бусад хуулиар гэр бүлийн харилцааг зохицуулдаг билээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 11-д “улс төр, эдийн засаг, нийгэм соёлын амьдрал, гэр бүлийн харилцаанд эрэгтэй, эмэгтэй тэгш эрхтэй. Гэрлэлт нь хуулиар тогтоосон насанд хүрсэн эрэгтэй, эмэгтэй хоёрын тэгш эрх, сайн дурын харилцаанд үндэслэнэ. Гэр бүл, эх нялхас, хүүхдийн ашиг сонирхлыг төр хамгаална” гэж заасан. Түүнчлэн Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” хэмээн хуульчилсан байна.

Ийнхүү Монгол Улс нь Үндсэн хуульдаа тунхагласан хүний эрх, эрх чөлөөг хангах баталгааг бүрдүүлэх үүргийнхээ дагуу Гэр бүлийн тухай бие даасан хуулийг 1999 онд батлан мөрдүүлсэн.¹

Гэр бүлийн тухай хууль хэрэгжиж эхэлснээс хойших 18 жилийн хугацаанд тус хуульд нийт 5 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан боловч эдгээр нэмэлт, өөрчлөлтүүд нь гэр бүлийн харилцаанд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн гэхээс илүүтэй салбарын харилцааг зохицуулсан бусад хуулийн шинэчлэлийг дагалдан хийгдсэн байна. Тодруулбал, 2002 онд Иргэний хуулийн, 2011 онд Нотариатын тухай хуулийн шинэчлэлтэй, 2012 онд Эвлэрүүлэн зуучлалын тухай,

¹ www.legalinfo.mn. Сүүлчийн нэвтрэлт 2017 оны 12 сар.

2016 онд Хүүхэд хамгааллын тухай хууль батлагдсантай холбоотой Гэр бүлийн тухай хуульд тус тус нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.²

Монгол Улсын Засгийн газраас гэр бүлийн харилцаанд тулгамдаад байгаа асуудлыг шийдвэрлэх, гэр бүлийн хөгжил, бүрэн бүтэн байдлыг дэмжих чиглэлд эрх зүйн цогц шинэчлэл хийх зорилтыг дэвшүүлж Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн³ 3.4.-т "...гэр бүлийн гишүүдийн хариуцлагыг нэмэгдүүлэх эрх зүйн таатай орчинг бүрдүүлнэ" гэж, 3.4.1-д "Гэр бүл, хүүхэд, залуучуудын асуудал эрхэлсэн төрийн байгууллагын бүтцийг бий болгоно." гэж тус тус заасан байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын 2017 оны 11 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл"-ийн 175-д Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулахаар төлөвлөсөн байна.

Монгол Улсын төрөөс гэр бүлийн хөгжлийн талаар баримтлах бодлогын "Гурав"-ын 1.2-т "гэр бүлийг бэхжүүлэх эрх зүй, эдийн засаг, дэвшилтэт уламжлал, зан заншлыг өвлүүлэх орчинг бүрдүүлэх" гэж, 1.3-т "гэр бүлийн харилцаанд жендерийн тэгш байдлыг хангаж, эцэг, эх, нөхөр, эхнэрийн нэр хүнд, гэр бүлийн бусад гишүүддээ хандах хандлага, боловсролыг дээшлүүлэх" гэж, 1.4-т "гэр бүлийн харилцааны эрх зүйн орчинг боловсронгуй болгож, хүүхэд, эмэгтэйчүүд, ахмад настны эсрэг хүчирхийллийг таслан зогсоох" гэж, "Дөрөв"-ийн 4.3-т "гэр бүлийн маргааныг гэр бүлийн асуудлаар мэргэшсэн шүүгч шийдвэрлэдэг болох" гэж тус тус заасан.

Төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогын 4.3.3-т "гэр бүлийн гишүүдийн тэгш эрх, үүрэг, хариуцлага, оролцоог хангах" гэж, 4.3.4-т "хүүхэд бүрийг гэр бүл, нийгмийн ээлтэй орчинд эсэн мэнд, аюулгүй, хүчирхийллээс ангид өсөх орчныг бүрдүүлэх" гэж, 4.3.5-т "гэр бүлийн харилцааны тогтвортой байдлыг дэмжих"-гэж тус тус заасан.

Дээр дурдсан Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ болон бодлогын баримт бичгүүдэд заасан зохицуулалт нь Гэр бүлийн тухай хуульд шинэтгэл хийх хууль зүйн үндэслэл болж байна.

1.2. Практик үндэслэл, шаардлага

Гэрлэлтээ батлуулахгүйгээр хамтран амьдрах, гадаадын иргэнтэй гэр бүл болох зэргээр иргэд гэр бүлийн харилцаанд чөлөөтэй хандах болсон төдийгүй гэрлэлт цуцлалт, гэр бүлийн гишүүдийн хөрөнгийн маргаан, гэр бүл дэх хүүхдийн эрхийн зөрчил нэмэгдэж байгаа нь гэр бүлийн харилцаанд төрийн оролцоо бүхий илүү нарийвчилсан зохицуулалт шаардлагатай байгааг харуулж байна.

² Монгол Улсын статистик мэдээлэл. 2017 он Үндэсний статистикийн хороо

³ Монгол Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолын хавсралт.

Монгол Улсын хэмжээнд 2010 онд 9349 хос гэрлэлтээ бүртгүүлж, 3054 гэр бүл гэрлэлтээ цуцлуулж байсан бол 2016 онд 16778 хос гэрлэлтээ бүртгүүлж, 4003 хос гэрлэлтээ цуцлуулсан байна.

Энэхүү статистик мэдээллээс дүгнэхэд жилд дунджаар гэрлэлт 13 хувиар, гэрлэлт цуцлалт 5,1 хувиар нэмэгдсэн байна.⁴

Гэрлэлт цуцлалтын тохиолдлыг гэр бүл байсан хугацаагаар нь судлахад “Он цаг өнгөрөх тутам гэр бүл бат тогтвортой байдаг” гэсэн хэвшмэл ойлголтын эсрэг үр дүн гарч байна. Тухайлбал, 2016 онд гэрлэлтээ цуцлуулсан хосын 51.6 хувь нь 10-аас дээш жил, 26.5 хувь нь 7-9 жил, 14.7 хувь нь 4-6 жил, үлдсэн 7,1 хувь нь 3 хүртэл жил хамт амьдарсан байна.⁵

Гэрлэлт цуцлалтын гол шалтгаанд үзэл бодлын зөрчил, үл ойлголцол, хардалт зэрэг гэр бүлийн гишүүдийн хэвийн бус харилцаанаас үүдэлтэй шалтгаан өндөр хувийг эзэлж байгаа⁶ нь иргэдийн дунд гэр бүлийн боловсрол хангалтгүй байгаатай холбоотой байна.

Гэр бүлийн тогтвортой хамтын амьдралыг дэмжих, гэр бүлд зөвлөгөө өгөх, гэр бүлийн боловсрол олгох зэрэг арга хэмжээг сургалт судалгааны болон иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран зохион байгуулдаг ч төдийлөн үр дүнтэй биш байна. Гэтэл судалгаанд оролцогчдын 72.3 хувь нь гэр бүлд боловсрол олгох газар, зөвлөгөө өгөх төв шаардлагатай гэж үзсэн⁷ нь иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, зөвлөгөө өгөх үйлчилгээ нэн хэрэгцээтэй байгааг харуулж байна.

Энэ нь тус үйлчилгээг төрийн нэгдсэн зохицуулалт бүхий тогтвортой, мэргэшсэн хэлбэрээр хөгжүүлээгүйтэй холбоотой байна.

Гэрлэлт цуцлалт, гэр бүлийн таагүй уур амьсгал, хүчирхийллийн харилцааны улмаас хүүхдэд тавих эцэг, эхийн анхаарал, халамж суларч хүүхдийн аж байдал, сурлага, хүмүүжилд сөрөг нөлөө үзүүлж, хүүхэд эцэг, эх, гэр бүлээсээ дайжин гудамж, асрамж, халамжийн газруудад амьдрах, гэмт хэрэгт холбогдох, хорих газар ял эдлэх, хүнд хөдөлмөр эрхлэх, хүний наймаа, бэлгийн мөлжлөгийн золиос болох, мөн олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох зэрэг эрсдэлд өртөж байна.

2016 оны байдлаар гэр бүлийн орчноос байнга болон түр хугацаагаар тусгаарлагдаж асрамж, халамжийн газарт 1060 хүүхэд амьдарч байгаагийн дотор хараа хяналтгүй 74 хүүхэд, гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 142 хүүхэд байна.⁸

2016 онд Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газрыг байгуулсан нь чухал үр дүнтэй алхам болсон бөгөөд тус хэрэгжүүлэгч агентлаг нь хүн ам, гэр бүл, хүүхэд, залуучуудын талаарх хууль, бодлого, шийдвэрийн хэрэгжилтийг бүх түвшинд хангахад анхаарч ажилласны дүнд төрийн үйлчилгээ анхан шатанд болон хүн амын

⁴ Монгол Улсын статистик мэдээлэл. 2017 он Үндэсний статистикийн хороо

⁵ Монгол Улсын статистик мэдээлэл. 2017 он Үндэсний статистикийн хороо

⁶ Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. 2010 он. НХХЯ, ФСЭЗХ, НҮБХАС, УИС

⁷ Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгаа. 2013 он. ҮСХ,НҮХС, НҮБХАС

⁸ Монгол Улсын статистик мэдээлэл. 2017 он Үндэсний статистикийн хороо

бүх бүлэгт жигд хүрч иргэдийн оролцоо нэмэгдсэн, хүүхдийн хараа хяналт, хамгаалал сайжирсан, гэр бүлийн боловсрол олгох үйлчилгээ жигдэрч эхэлж байгаа зэрэг нийгэмд олон зэрэг өөрчлөлт гарч байна.

Мөн тус агентлагийн дэргэд Хүүхдийн асрамжийн Өнөр бүл төв, Хүүхдийн тусламжийн утас 108 төв, Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний түр хамгаалах байрыг тус тус байгуулан ажиллаж байна.

Иймд тус агентлагийн байнгын тогтвортой үйл ажиллагааг хангах зорилгоор чиг үүргийг хуульчлан зохицуулах нь чухал байна.

Эцэг, эхийн хүүхдээ тэжээн тэтгэх үүргийн дагуу шүүхээс тэтгэлэг тогтоодог боловч бодит байдалд хүүхдийн тэтгэлэг бүрэн төлөгдөхгүй, түүнээс улбаалан хүүхдийн наад захын хэрэгцээ хангагдахгүй байх, хоол тэжээлийн доройтолд орох зэргээр хүүхдийн амьд явах, эрүүл өсөн бойжих, сурч боловсрох нөхцөлийг сулруулж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн мэдээнээс үзэхэд хүүхдийн тэтгэлгийн 50 гаруй хувь нь огт төлөгддөггүй бөгөөд үүнд ажилгүйдэл, ядуурал, иргэдийн төлбөрийн чадваргүй байдлаас гадна хариуцлага сул байдал нөлөөлж байна.

Түүнчлэн өнөөдөр хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Гэр бүлийн тухай хуульд гадаадын иргэн болон харьяалалгүй этгээд оролцсон гэр бүлийн харилцааны онцлогийг үл харгалзан дотоодын гэрлэлтийн нэгэн адил нийтлэг байдлаар зохицуулсан нь бэрхшээл үүсгэж байна.

Монгол Улсын иргэний бүртгэлийн мэдээллээс үзэхэд 1998-2016 оны хооронд Монгол Улсын 5970 иргэн гадаадын иргэдтэй гэр бүл болсон бол 1017 иргэн гэрлэлтээ цуцлуулж, Монгол Улсын харьяат 266 хүүхэд гадаадын иргэдэд үрчлэгдсэн байна.⁹

Гэр бүлийн асуудлаар явуулсан судалгаанд оролцогчдын 46.2% нь даяаршсан нийгэмд гадаад хүнтэй гэрлэхийг байх л асуудал гэж үзсэн¹⁰ нь гадаадын харьяат иргэдтэй гэрлэх гэрлэлтийн талаарх олон нийтийн хандлага өөрчлөгдсөнийг харуулж байна.

Гэтэл практикт гадаадын иргэнтэй гэр бүл болох, гэрлэлт цуцлахтай холбоотой Монгол Улсын болон гэрлэгчдийг харьяалах улсын хуулийн зохицуулалтын зөрүүтэй байдал, хүүхдийн асрамж, тэтгэлэг, хөрөнгийн маргаан гээд эрх зүйн шийдэл шаардсан олон асуудлууд байна.

Иймд гэр бүлийн харилцааны эрх зүйн орчинг сайжруулах, гэр бүлийн харилцаанд тулгамдаж байгаа асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах практик шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

⁹ Оюуны өмч, улсын бүртгэлийн ерөнхий газрын статистик мэдээлэл. 2017 он

¹⁰ Монгол гэр бүлийн харилцааны өнөөгийн байдал. 2010 он. НХХЯ, ФСЭЗХ, НҮБХАС, УИС

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хүрээнд төрөөс гэр бүлийн тогтвортой хамтын амьдралыг дэмжих, гэр бүлийн талаар явуулж буй бодлого, үйлчилгээг гэр бүлд шуурхай хүргэх үүрэг бүхий гэр бүлийн хөгжлийг дэмжих төрийн байгууллагын чиг үүргийг тодорхойлж, иргэдэд гэр бүлийн боловсрол олгох, гэр бүлд зөвлөгөө өгөх, гэр бүл дэх хүүхэд хамгаалал, хүүхдийн өмчийн эрхийн асуудлыг баталгаажуулах, хосуудын бие биенийхээ өмнө болон гэр бүлийн бусад гишүүдийн өмнө хүлээх үүрэг, хариуцлагыг сайжруулах, хүүхдийн тэтгэлэг бодитой, цаг хугацаандаа төлөгдөх нөхцөл, механизмыг бүрдүүлэх, гадаадын харьяат иргэн оролцсон гэр бүлийн асуудлыг нарийвчлан зохицуулах шаардлагатай байна.

Эдгээр практик шаардлагыг үндэслэн Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

Гэр бүлийн тухай хуулийг шинэчлэн найруулах хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан¹¹ дүгнэлтээр төрөөс гэр бүлийг дэмжих бодлогыг тодорхойлох, хэрэгжүүлэх бүтэц, механизмыг хуулиар баталгаажуулах, гэр бүлийн гишүүдийн үүрэг хариуцлагыг тодруулах, гадаадын иргэн оролцсон гэр бүлийн харилцааг нарийвчлан зохицуулах, гэр бүл дэх хүүхдийн эрхийн баталгааг сайжруулах өргөн хүрээг хамруулан Гэр бүлийн тухай хуулийг шинэтгэх шаардлагатай байна.

Иймд Гэр бүлийн тухай хуулийн шинэчлэл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1.2 болон 25.1.4-т заасны дагуу гэр бүлийн харилцааны төлөв байдал, агуулгад нийцүүлэн шинэ зохицуулалтыг бий болгох, өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хуулийн нийт заалтын тавиас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлага тулгарч байгаа тул хуулийн төслийг шинэчилсэн найруулгын хэлбэрээр боловсруулна.

Хуулийн төслийн зохицуулах харилцаа, хамрах хүрээг дээр дурдсан үндэслэл, шаардлагад тулгуурлан дараахь агуулгаар тодорхойлно:

1.Хуулийн зорилгыг шинэчлэн тодорхойлж, төрөөс гэр бүлийн хөгжлийг дэмжих, гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилтыг тусган өргөжүүлнэ.

2.Төрөөс гэр бүлийн тогтвортой хамтын амьдралыг дэмжих, гэр бүлийн талаар явуулж буй бодлого, үйлчилгээг гэр бүлд шуурхай хүргэх үүрэг бүхий гэр бүлийн хөгжлийг дэмжих төрийн байгууллагын чиг үүргийг хуульчилж, өнөөдөр гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр дагнасан чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн захиргааны байгууллагын бүтэц, зохион байгуулалтыг хуулиар баталгаажуулна.

¹¹ Хууль тогтоомжийн тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу ХНХЯ-наас хийсэн судалгаа. 2017 он.

3.Гэрлэлт сайн дурын үндсэн дээр байх зарчимд нийцүүлэн гэрлэлт зуучлалын үйлчилгээ эрхлэхийг хориглох, цус ойртолт, удамших хандлагатай халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гэрлэхийг хүсэгчдийн эрүүл мэндийн шинжилгээг өргөжүүлнэ.

4.Гэр бүлийн гишүүдийн, тэр дундаа эцэг, эхийн хүлээх үүргийг нэмэгдүүлж, хүүхэд эрүүл, аюулгүй орчинд өсөж бойжих нөхцөлийг хангах, хүмүүжлийн зэрэг аргыг хэрэглэх, хүүхдэд ёс заншил, түүх соёлын уламжлал, суурь боловсрол эзэмшүүлэх, амьдрах арга ухаанд сургах, хөдөлмөрт бэлтгэх зэрэг үүргээ биелүүлэхэд нь төрөөс дэмжлэг үзүүлэх нөхцөл, журмыг тодорхойлно.

5.Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг гэр бүлдээ авч хүмүүжүүлж буй асралт гэр бүлд тавигдах шалгуур болон төрөөс үзүүлэх дэмжлэг, хяналтын зохицуулалтыг тусгана.

6.Хүүхэд үрчлэлт нь хүүхдийн язгуур ашиг сонирхолд нийцсэн байх зарчмын дагуу нөхцөл байдлын үнэлгээг үндэслэн үрчлэлтийн асуудлыг шийдвэрлэх, үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалд тогтмол хяналт тавих журмыг хуульчилна.

7.Гадаадын иргэн, харьяалалгүй этгээд оролцсон гэр бүлийн харилцааг нарийвчлан зохицуулж, гадаадын харьяат иргэнд хүүхэд үрчлүүлэх, үрчлэгдсэн хүүхдийн нөхцөл байдалд тавих хяналтыг сайжруулна.

8.Иргэдэд гэр бүлийн боловсролыг албан болон албан бус хэлбэрээр бүх түвшинд олгох, гэр бүлийн боловсрол олгох төвүүдийг байгуулж ажиллуулах, энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ТББ-тай хамтран ажиллах эрх зүйн үндсийг шинээр бий болгоно. Мөн төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллагуудын гэр бүлийг дэмжих үйлчилгээг урамшуулах, хөхиүлэн дэмжих эрх зүйн үндсийг хуульд шинээр зохицуулна.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар, тэдгээрийг шийдвэрлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг боловсруулж баталснаар гэр бүлийн тогтвортой хамтын амьдрал, хөгжлийг төрөөс дэмжих эдийн засаг, эрх зүй, нийгэм, сэтгэл зүйн орчин бүрдэнэ.

Түүнчлэн гэр бүлд суурилсан хөгжил, хамгааллын бодлого хэрэгжих, төрийн үйлчилгээ гэр бүлд хүрэх бодит нөхцөл бүрдэж, өнөөдөр гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжил, хамгааллын чиглэлээр дагнасан чиг үүргийг хэрэгжүүлж буй төрийн захиргааны байгууллагын ажиллах эрх зүйн зохицуулалт баталгаажна.

Ийнхүү гэр бүлийн харилцааны олон талт, түвэгтэй асуудлыг хуулиар нарийвчлан зохицуулснаар гэр бүлийн гишүүдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол тэнцвэртэй хангагдаж, гэр бүлийн хүчирхийлэл, гэрлэлт цуцлалт буурна.

Хэдийгээр тус хуулийн дагуу улсын төсвөөс тодорхой зардал гарах боловч хуулийг хэрэгжүүлснээр өнөөдөр тулгамдаад байгаа олон бэрхшээлийг шийдвэрлэхийн зэрэгцээ дээр дурдсан эерэг үр дүнд хүрэх болно.

Тус хуулийг батлан хэрэгжүүлэхтэй холбоотой гарах эдийн засгийн үр дагаврын тооцоог Хууль тогтоомжийн тухай хуульд заасны дагуу тусгайлан хийнэ.

Дөрөв.Хуулийн төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, уг хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Гэр бүлийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хууль, Иргэний хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээтэй нийцүүлэн боловсруулна.

Тус хуулийн төсөлтэй холбогдуулан Гэр бүлийн тухай хуулийг хүчингүй болгох тухай, Иргэний бүртгэлийн тухай, Иргэний болон Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг хамтад нь боловсруулна.

---o0o---